Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлагдсан эсэх[4]		1	1	100
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0	0
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0.5	0.5	100
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0.5	0.5	100
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0.5	0.5	100
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0.5	0.5	100
Хэсгийн оноо				**4**	**2.5**	**62.5**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(өмнөх дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд өмдол)*		1	1	100
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд		1	1	100
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	1	100
Хэсгийн оноо				**3**	**3**	100
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	100
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт*		1	1	100
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	100
Хэсгийн оноо				**3**	**3**	100
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**8.5**	**85**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:

[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.

[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.

[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр".

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн батлагдсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, сэдэв батлах тухай" тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.

[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.

[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.

[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.

[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.

[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дүгээр
сарын 04-ний өдрийн 09 дугаар тогтоолын
хавсралт



ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ.Товч танилцуулга[2]

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт Ёс зүйн дэд хороо нь байгууллагын албан хаагчийн тооноос хамааран 3-7 гишүүнтэй байх бөгөөд гишүүд дотроосоо даргаа сонгоно хэмээн заасан. Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.4 дэх хэсэгт 40 ба түүнээс цөөн төрийн албан хаагчтай байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 3 гишүүн, 41 – 90 бол 5 гишүүн, 91-дээш бол 7 гишүүнтэй байна хэмээн заасны дагуу тус газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Ёс зүйн дэд хорооны дарга: Жавхланбаярын **АНХБАЯР**-Цахим ур чадвар, олон нийттэй харилцах газрын дарга

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга: Наранхүүгийн **АЛТАНСУВД**-Цахим ур чадварын хэлтсийн дарга

Ёс зүйн дэд хорооны гишүүн: Жаргалсайхан **ДАВААСҮРЭН**-Цахим цахим үйлчилгээ хариуцсан хэлтсийн дарга

Цэен-Ишийн **БЯМБАЖАВ**-Завхан аймгийн цахим шилжилт, үйлчилгээний хэлтсийн дарга

Баяраагийн **ДОВДОНЦЭРЭН**-Төв аймгийн цахим шилжилт, үйлчилгээний хэлтсийн дарга

Алтангадасын **НОМИН**-Захиргаа удирдлагын газрын Хуулийн ахлах мэргэжилтэн

Доцоогийн **ОЮУНЧИМЭГ**- Чанар хяналтын газрын Ахлах мэргэжилтэн

ХОЁР.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, 2025 оны сургалтын календарчилсан төлөвлөгөөг боловсруулан баталсан.

2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр "Бонум" ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал М.Тэмүүлэнг урьж "Өөрийгөө бүтээхүй" сургалтыг цахим болон танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулж байгууллагын нийт албан хаагчийг хамруулсан.

2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 01/464 дугаартай албан бичгээр Монгол Улсын Ёс зүйн хороонд байгууллагын нийт албан хаагчдад сургалт авах хүсэлтийг хүргүүлж 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх

хэлтсийн дарга Ц.Заяхүү, Соён гэгээрүүлэх хэлтсийн дэд хороо хариуцсан ахлах мэргэжилтэн Мөнхжин нар “Байгууллагын соёл, албан хаагчийн ёс зүй” сэдвээр сургалт зохион байгуулж байгууллагын нийт 154 албан хаагчийг хамруулсан. Шинээр ажилд орсон 6 албан хаагчид 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр тус газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, холбогдох асуудлын талаар сургалтыг тус газрын Захиргаа удирдлагын газартай хамтран зохион байгуулсан. 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Систем нэгтгэлийн хэлтэс дээр томилогдсон 1, Хамтын ажиллагаа, хэрэглэгчийн үйлчилгээний хэлтэст томилогдсон 2 албан хаагчид Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийн тухай сургалтыг тус газрын Захиргаа удирдлагын газартай хамтран зохион байгуулж нийт 3 албан хаагчийг хамруулсан. 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Систем нэгтгэлийн хэлтэст томилогдсон 1, үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газрын Аймаг хариуцсан хэлтэст томилогдсон 1 албан хаагч, Сургалт хөгжлийн хэлтэст томилогдсон 1 албан хаагчид Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийн тухай сургалтыг тус газрын Захиргаа удирдлагын газартай хамтран зохион байгуулж нийт 3 албан хаагчийг хамруулсан. 2025 оны 11 дүгээр сарын 04, 05-ны өдрүүдэд Нийслэл хариуцсан хэлтэст шинээр томилогдсон албан хаагчдад Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж журамтай холбоотой 2 удаагийн сургалт зохион байгуулж 14 албан хаагчийг хамруулсан. 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” цахим мэдээллийн цагийн хөтөлбөрийн “Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтад нийт албан хаагчийг хамруулсан. Байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ээлжит судалгааг 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдөр авч үр нэгтгэн тайлагнаж ажилласан. Цахим ур чадвар, олон нийттэй харилцах газрын нийт албан хаагчдаас нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа авч нэгтгэсэн. 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдөр нийт албан хаагчдын дунд санал асуулга явуулж байгууллага, хамт олноо ёс зүйгээр манлайлагч 3 албан хаагчийг шалгаруулсан.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Тус газрын дэргэдэх ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж соён гэгээрүүлэх арга хэмжээнд нийт албан хаагчдын оролцоог хангаж ажилласан. Дэд хорооны гишүүдийн урамшууллыг 3 улирал олгосон.

---

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:	
Удирдах албан тушаалтантай холбоотойгоор 2024 онд ирүүлсэн 2 гомдлыг 2025 оны 01 дүгээр сард "Ёс зүйн зөрчил гаргасан тухай" дүгнэлт хүргүүлсэн. 2025 оны 02 дугаар сард ирсэн гүйцэтгэх албан хаагчтай холбоотой 1 гомдлыг хянан шалгаж ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдон холбогдох дүгнэлтийг хүргүүлсэн. 2025 оны 04 дүгээр сард төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтантай холбоотой 1 ирснийг хянан шалгаж зөрчил тогтоогдоогүй тухай дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. 2025 оны 04 дүгээр сард төрийн үйлчилгээний гүйцэтгэх албан тушаалтантай холбоотой 1 гомдол ирснийг хянан шалгаж зөрчил тогтоогдоогүй тухай дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. 2025 оны 06 дугаар сард төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтай холбоотой 1, гүйцэтгэх албан тушаалтантай холбоотой 1 гомдол ирснийг хянан шалгаж зөрчилгүй гаргаагүй тухай дүгнэлтийг холбогдох албан хаагчдад хүргүүлсэн. Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шинээр ажилд орсон ажилтнуудыг чиглүүлэх сургалтыг зохион байгуулахад холбогдох журмын дагуу хамтран ажиллах тухай У-03/01 дугаартай албан бичгээр Захиргаа удирдлагын газар болон Сургалт хөгжлийн хэлтэст тус тус зөвлөмж хүргүүлсэн. Ёс зүйн зөрчлийн бүртгэл хяналтын дэд системд 2024 оны үйл ажиллагааны тайланг, өргөдөл гомдлын бүртгэлийг нөхөж оруулсан. 2025 онд ирсэн 1 гомдлыг системд бүртгэл үүсгэсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо, Ёс зүйн хороонд тус газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөний нэгдүгээр улирал, хагас жил, гурав дугаар улирлын байдлаар биелэлтийг хүргүүлсэн.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
2025 оны хагас жилээс хойш нэг ч гомдол хүлээж аваагүй. Байгууллагын дотоод уур амьсгал, албан хаагчдын харилцаа хандлага сайжирсан.	Төсөв санхүүгийн хүрэлцээ багаас үүдэн соён гэгээрүүлэх арга хэмжээ, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулахад бэрхшээл тулгарч байна.
Санал:	
Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайлангийн загварыг цөөн болгох, цахим системд бүртгэлтэй дэд хорооны тайланг системээс татаж авах ба цаасаар, албан бичгээр тайлан авахгүй байх боломжоор хангаж ажиллах Дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулах	

Шалгах хэсэг:

- ☐ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Төрийн цахим үйлчилгээний
зохицуулалтын газрын дарга /Ц.Борхүү/


Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Цахим ур чадварын хэлтсийн дарга /Н.Алтансувд/

Огноо: 2018 оны 01 сарын 05

Төлөвлөгөө батлсан:

Төрийн цахим үйлчилгээний
зохицуулалтын газрын дэргэдэх
Ёс зүйн дэд хорооны дарга ..... /Б.Одбаяр/
2025.01.30



Төлөвлөгөө боловсруулсан:

Төрийн цахим үйлчилгээний
зохицуулалтын газрын дэргэдэх
Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга ..... /Н.Алтансувд/
2025.01.30

ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хугацаа /улирлаар/		Хариуцах гишүүн
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил	
1.	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	Төлөвлөгөөний тоо	1	1	-	Н.Алтансувд
2.	Сургалтын хөтөлбөр боловсруулж батлах, хэрэгжилтийг хангаж ажиллах	Төлөвлөгөөний тоо	1	1	-	Н.Алтансувд
3.	Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Сургалтын тоо	2	1	1	Ж.Даваасүрэн
4.	Шинээр ажилд орсон албан хаагчдад ёс зүйн асуудлаар сургалт зохион байгуулахад холбогдох нэгжтэй хамтран ажиллах	Сургалтын тоо	8	4	4	Д.Оюунчимэг
5.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах	Дүгнэлтийн тоо	Тухай бүр	Тухай бүр	Тухай бүр	А.Номин Ж.Даваасүрэн Д.Оюунчимэг Б.Довдонцэрэн

						Ц.Бямбажав
6.	Холбогдох нэгжүүдэд ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх	Хүргүүлсэн зөвлөмжийн тоо	5	2	3	А.Номин
7.	Байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа хийх	Судалгааны тоо	2	1	1	А.Номин Ж.Даваасүрэн Д.Оюунчимэг Б.Довдонцэрэн Ц.Бямбажав
8.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж Ёс зүйн хороонд хүргүүлэх	Тайлангийн тоо	2	1	1	Н.Алтансувд
9.	Ээлжит хуралдааныг жил бүрийн 6, 12 дугаар сарын сүүлийн долоо хоногт зохион байгуулах	Хуралдааны тоо	2	1	1	Н.Алтансувд
10.	Ёс зүйн зөрчил гаргасан талаар гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх хуралдааныг тухай бүр зохион байгуулах	Хянан шийдвэрлэсэн гомдол мэдээллийн тоо	Тухай бүр	Тухай бүр	Тухай бүр	Н.Алтансувд
11.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтийн талаар олон нийтэд тогтмол мэдээлэх	Мэдээллийн тоо	5	2	3	Ц.Бямбажав
12.	Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар явуулах	Арга хэмжээний тоо	2	1	1	Ж.Даваасүрэн
13.	Ёс зүйтэй албан хаагчийг алдаршуулах ажлыг зохион байгуулах	Арга хэмжээний тоо	4	2	2	Д.Оюунчимэг
14.	Дэд хорооны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн самбар хийх	Мэдээллийн самбарын тоо	1	1	-	А.Номин Ж.Даваасүрэн Д.Оюунчимэг Б.Довдонцэрэн Ц.Бямбажав

Төлөвлөгөө батлсан:

Төрийн цахим үйлчилгээний
зохицуулалтын газрын дэргэдэх
Ёс зүйн дэд хорооны дарга



/Б.Одбаяр/
2025.01.30

Төлөвлөгөө боловсруулсан:

Төрийн цахим үйлчилгээний
зохицуулалтын газрын дэргэдэх
Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

/Н.Алтансувд/
2025.01.30

ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ СУРГАЛТЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Сургалтын агуулга	Зорилтод бүлэг	Хугацаа /сараар/												Хариуцах гишүүн
			I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
1.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль	Нийт албан хаагчид					+						+		Н.Алтансувд
2.	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ						+						+		
3.	Ёс зүйн дэд хорооны ажиллах журам						+						+		
4.	"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр					+				+		+			Ц.Бямбажав
5.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам				+				+					+	Б.Довдонцэрэн

6.	Шинээр ажилд орсон албан хаагчдад зориулсан сургалт	Шинээр томилогдсон албан хаагчид	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	+	Ж.Даваасүрэн Д.Оюунчимэг ЗУГ
7.	Бусадтай харилцах ур чадвар	Нийт албан хаагчид			+										А.Номин СХХ
8.	Байгууллагын соёл						+								
9.	Хөдөлмөрийн ёс зүй ба ёс суртахуун								+						
10.	Сэтгэл хөдлөлөө удирдах										+				
11.	Төрийн үйлчилгээний стандарт, соёл, төрийн албаны нэр хүнд														